



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/017/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086381
Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Э.Сүнжидмаа
Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13.
Цахим шуудан: govialta@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Л.ГАНХУЯГ ТАНАА

2025, 02.21 № 27

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Орон нутгийг өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутагт ажилласны нэмэгдлийг 222.8 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон,
- Төсвөөс 10,000.0 мянган төгрөгөөр компьютер техник худалдан бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,

8225020073

- Санхүүгийн тайланд олон жилийн насжилттай авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй,
- Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудтай дуусгалын тооцоо хийгээгүй,
- Санхүүгийн ажилтанд урамшуулал олгоходоо хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй 2206.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2023 оны өмчийн нэгдсэн сургалт, спортын арга хэмжээ зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын дансанд бүртгэлтэй 161,319.1 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр дуудлага худалдаагаар худалдан борлуулсан, 61,650.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн байна.

Бусад асуудал

Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилт 42 арга хэмжээний хэрэгжилт 98.2 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>42,692,925.00</u>	<u>42,630,925.00</u>
33	АВЛАГА	41,377,425.00	41,377,425.00
335	Бусад авлага	41,377,425.00	41,377,425.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	41,377,425.00	41,377,425.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,315,500.00	1,253,500.00
354	Хангамжийн материал	1,315,500.00	1,253,500.00
35410	Бичиг хэргийн материал	628,500.00	566,500.00
35420	Аж ахуйн материал	687,000.00	687,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>179,177,971.72</u>	<u>30,687,936.71</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	179,177,971.72	30,687,936.71
392	Биет хөрөнгө	110,997,971.72	30,687,936.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	93,139,066.34	-
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,586,360.20)	(0.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,650,000.00	91,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,611,870.50)	(76,833,333.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,909,035.00	17,387,035.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,867,440.62)	(4,561,431.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,824,000.00	4,645,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,458,458.30)	(1,650,133.29)
393	Биет бус хөрөнгө	68,180,000.00	-
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	68,180,000.00	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>221,870,896.72</u>	<u>73,318,861.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>597998.50</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	597,998.50
413	Өглөг	0.00	597,998.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	29,998.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	568,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>221,870,896.72</u>	<u>72,720,863.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	221,870,896.72	72,720,863.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,180,000.00	-
51101	Өмч: - төрийн	68,180,000.00	-
512	Хуримтлагдсан үр дүн	113,417,230.50	72,720,863.21
51210	Өмнөх үеийн үр дүн	111,935,724.64	153,690,896.72
51220	Тайлант үеийн үр дүн	1,481,505.86	(80,970,033.51)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,273,666.22	(0.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>221,870,896.72</u>	<u>73,318,861.71</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	354,485,975.53	422,313,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,612,463.03	3,720,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,612,463.03	3,720,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,612,463.03	3,720,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,702,463.03	3,720,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,873,512.50	418,592,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,906,312.50	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,200,000.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	314,967,200.00	416,592,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,967,200.00	416,592,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	341,098,095.09	429,246,845.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,098,095.09	429,246,845.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,880,907.22	411,498,134.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,027,424.06	306,443,465.30
210101	Үндсэн цалин	137,999,839.49	177,541,630.60
210102	Нэмэгдэл	55,617,834.32	66,462,370.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,795,000.00	22,359,999.40
210104	Урамшуулал	12,693,447.82	15,109,199.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,921,302.43	24,970,266.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,915,223.57	38,305,420.68
210201	Тэтгэврийн даатгал	19,698,916.20	26,048,679.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,313,726.23	3,063,434.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,846,581.00	1,532,217.36
210204	Ажилгүйдлийн даатгал	459,635.60	1,532,217.36
210205	Эрүүл мэндийн даатгал	4,596,364.54	6,128,871.67
2104	Хангамж, бараа материалын зардал	12,551,658.00	11,549,943.00
210401	Бичиг хэрэг	4,985,450.00	3,953,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	3,954,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,566,208.00	3,642,043.00
2107	Томилолт, зочны зардал	13,858,000.00	11,873,000.00
210702	Дотоод албан томилолт	13,858,000.00	11,873,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,125,719.00	16,662,259.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,286,270.00	14,990,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	354,250.00	274,259.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	895,000.00	695,000.00
210807	Газрын төлбөр	569,255.00	681,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,479,082.59	26,664,046.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,262,500.00	3,690,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,004,000.00	2,979,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,212,582.59	19,994,046.96

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,217,187.87	17,748,710.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	17,308,049.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	16,219,549.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	1,088,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,317,187.87	440,661.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,317,187.87	440,661.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,387,880.44	(6,933,245.46)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,906,374.58	74,036,788.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,906,374.58	74,036,788.05
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,906,374.58)	(74,036,788.05)
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,481,505.86	(80,970,033.51)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	327,783,512.50	418,592,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,873,512.50	418,592,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,906,312.50	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,200,000.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	314,967,200.00	416,592,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,967,200.00	416,592,800.00
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	327,783,512.50	408,592,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,783,512.50	408,592,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,566,324.63	390,844,089.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,027,424.06	307,545,740.34
210101	Үндсэн цалин	137,999,839.49	178,643,905.64
210102	Нэмэгдэл	55,617,834.32	66,462,370.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,795,000.00	22,359,999.40
210104	Урамшуулал	12,693,447.82	15,109,199.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,921,302.43	24,970,266.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,915,223.57	37,173,147.14
210201	Тэтгэврийн даатгал	19,698,916.20	24,916,406.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,313,726.23	3,063,434.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,846,581.00	1,532,217.36
210204	Ажилгүйдлийн даатгал	459,635.60	1,532,217.36
210205	Эрүүл мэндийн даатгал	4,596,364.54	6,128,871.67
2104	Хангамж, бараа материалын зардал	12,449,658.00	11,487,943.00
210401	Бичиг хэрэг	4,883,450.00	3,891,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	3,954,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,566,208.00	3,642,043.00
2107	Томиллолт, зочны зардал	13,858,000.00	11,305,000.00

210702	Дотоод албан томилолт	13,858,000.00	11,305,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,125,719.00	16,662,259.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,286,270.00	14,990,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	354,250.00	274,259.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	895,000.00	695,000.00
210807	Газрын төлбөр	569,255.00	681,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,266,500.00	6,670,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,262,500.00	3,690,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,004,000.00	2,979,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,217,187.87	17,748,710.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	17,308,049.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	16,219,549.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	1,088,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,317,187.87	440,661.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,317,187.87	440,661.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	10,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	10,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	10,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(10,000,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	113,417,230.50	221,870,896.72
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	113,417,230.50	221,870,896.72
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	113,417,230.50	221,870,896.72
4	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	113,417,230.50	221,870,896.72

4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	40,273,666.22	40,273,666.22
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	153,690,896.72	262,144,562.94
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	(40,273,666.22)	0.00	(40,273,666.22)
7	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(68,180,000.00)	0.00	0.00	(68,180,000.00)
10	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(80,970,033.51)	(80,970,033.51)
11	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	72,720,863.21	72,720,863.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Орон нутгийн төсөв (төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,593,200.00	416,152,138.48	(441,061.52)	99.8
21	УРСГАЛ ЗАРДАГ	416,593,200.00	416,152,138.48	(441,061.52)	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,176,200.00	398,844,089.48	(332,110.52)	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,704,600.00	307,545,740.34	(158,859.66)	99.9
210101	Үндсэн цалин	307,704,600.00	178,643,905.64	(129,060,694.36)	58.0
210102	Нэмэгдэл	-	66,462,370.30	66,462,370.30	0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	22,359,999.40	22,359,999.40	0
210104	Урамшуулал	-	15,109,199.00	15,109,199.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	-	24,970,266.00	24,970,266.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,176,600.00	37,173,147.14	(3,452.86)	99.9
210201	Тэтгэврийн даатгал	24,637,800.00	24,916,406.10	278,606.10	101.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,133,900.00	3,063,434.65	(70,465.35)	97.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,566,900.00	1,532,217.36	(34,682.64)	97.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,566,900.00	1,532,217.36	(34,682.64)	97.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,271,100.00	6,128,871.67	(142,228.33)	97.7
2104	Хангамж, бараа материалын зардал	11,600,000.00	11,487,943.00	(112,057.00)	99.0
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	3,891,500.00	(2,108,500.00)	64.8
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	3,954,400.00		131.8

				954,400.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,600,000.00	3,642,043.00	1,042,043.00	140.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	10,305,000.00	10,305,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	10,305,000.00	10,305,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,673,000.00	16,662,259.00	(10,741.00)	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.00	14,990,000.00	(10,000.00)	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	275,000.00	274,259.00	(741.00)	99.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,000.00	22,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	695,000.00	695,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	681,000.00	681,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,717,000.00	5,670,000.00	(47,000.00)	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,717,000.00	3,690,400.00	(26,600.00)	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,979,600.00	(20,400.00)	98.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,417,000.00	17,308,049.00	(108,951.00)	99.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,417,000.00	17,308,049.00	(108,951.00)	99.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,320,000.00	16,219,549.00	(100,451.00)	99.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,097,000.00	1,088,500.00	(8,500.00)	99.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	416,593,200.00	416,592,800.00	(400.00)	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	416,593,200.00	416,592,800.00	(400.00)	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	416,593,200.00	416,592,800.00	(400.00)	100.0

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	2,000,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,000,000.00
21070 2	Дотоод албан томилолт		1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,000,000.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 669.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үнэ төлбөргүй шилжих ирсэн хөрөнгийг 669.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.Залруулагдаагүй нийт 67,270.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Залруулагдаагүй нийт 12,429.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 12,429.3 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрсэнд 4 албан шаардлага, 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүлээ..

3.1 Төлбөрийн акт

1. Орон нутагт ажилласны нэмэгдлийг 222.8 мянган илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40.0 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухай эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20.0 хувиар тус тус бодож сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Төсвөөс 10,000.0 мянган төгрөгөөр компьютер техник худалдан бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид зааснаас 2,206.5 мянган төгрөгөөр илүү урамшуулалт цалин олгосон нь:Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т /Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид нийцүүлэн цалин хөлсийг олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Санхүүгийн тайланд 41,377.4 мянган төгрөгийн олон жилийн насжилттай авлагын тооцоо нийлээгүй, барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион



байгуулах, удирдах", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажлаас чөлөөлөгдсөн 3 ажилтны амралтын дуусгалын тооцоо хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлтийг 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудтай дуусгалын тооцоог хуулийн дагуу хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Орон нутгийн өмчийн газар	Үнэ төлбөргүй шилжих ирсэн хөрөнгийг 669.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	669.8	-	-	1	669.8	1	669.8	-	-	-	-
Дүн		1	669.8	-	-	1	669.8	1	669.8	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Орон нутгийн өмчийн газар	Ажлаас чөлөөлөгдсөн 3 ажилтны амралтын дуусгалын тооцоо хийгээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-

